



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/174

Арвайхээр сум

Хөрөнгө оруулалтын чуулган зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.1.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Өвөрхангай аймгийн эдийн засгийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж, төр хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах замаар орон нутагт ажлын байрыг бий болгож, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотод “Growing Uvurkhangaï” хөрөнгө оруулалтын чуулганыг зохион байгуулсугай.

2. Чуулганыг зохион байгуулахад шаардагдах 121,288,364 (нэг зуун хорин нэгэн сая хоёр зуун наян найман мянга гурван зуун жаран дөрөв) төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0368

Аймгийн Засаг даргын 2024 оны... дугаар
сарын...-ны өдрийн... дугаар
захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг (мян төг)
1	Илтгэгчийн зардал	1,320,000
2	Сургалтын танхимын түрээс хоол, цайны зардал	75,253,000
3	Хэвлэлийн зардал	12,724,500
4	Орчуулгын зардал	6,750,000
5	Тээврийн зардал	1,610,000
6	Томилолтын зардал	14,000,000
7	Хэвлэл, мэдээллийн зардал	9,630,000
	Нийт дүн	121,288,400

-оОо-